



ДОРНОД АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 1108

Чойбалсан

Эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан  
сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ,  
оношилгоог зохион байгуулах ажлын хэсэг  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоол, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн хэмжээнд хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Багийн ахлагч:	Б.Сарнай	-Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
Нарийн бичиг:	П.Бибиш	-Эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Я.Эрдэнэтуяа	-Эрүүл мэндийн газрын Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтсийн дарга
	Ч.Оюунтунгалаг	-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
	Ж.Энхчимэг	-Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Б.Ууганбаяр	-Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
	Б.Энхмаа	-Эрүүл мэндийн газрын мэдээлэл сургалт, сурталчилгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Д.Ариунгэрэл	-Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан халдвар судлаач

310420283

Г.Дугармаа	-Эрүүл мэндийн газрын Статистик бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Улсын байцаагч
Г.Ариунзаяа	-Эрүүл мэндийн газрын Статистик бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Х.Эрдэнэцэцэг	-Эрүүл мэндийн газрын Эмийн чанар, аюулгүй байдал, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн
О.Мягмарсүрэн	-Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
Ц.Мөнхбаатар	-Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдээлэл технологийн тасгийн эрхлэгч
Б.Эрдэнэбаяр	-Бүсийн оношилгоо эмчилгээний Лабораторын эрхлэгч
С.Ариунтуяа	-Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Нягтлан бодогч
Б.Энхмаа	-Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Эм зүйн тасгийн эм зүйч  -Өрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга нар

2.Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах хүн амын тоон мэдээллийг нэгтгэн төлөвлөлт, тооцоолол, зураглалыг гарган, батлагдсан журам, товллын дагуу зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ч.Оюунтунгалаг)-т үүрэг болгосугай.

4.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, хүн амын дунд үзлэг, шинжилгээ, оношилгооны ач холбогдлыг сурталчлан, зохион байгуулж ажиллахад арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Сарнай), эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын талаар эрүүл мэндийн байгууллага, даатгуулагчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагааг зохион

байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (Б.Ууганбаяр)-т тус тус даалгасугай.

5.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хяналт зохицуулалтын нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ч.Оюунтунгалаг)- т даалгасугай.

6.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судлаачдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар хангаж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс (Я.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

7.Эрт илрүүлгийн цахим бүртгэлийн мэдээний сан байгуулах, хадгалах, баяжуулах, ашиглах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс (Я.Эрдэнэтуяа), эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сангийн өгөгдөл тогтмол солилцох ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (Б.Ууганбаяр), үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Сарнай)-т тус тус үүрэг болгосугай.

8.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны тайлан, мэдээнд тогтмол дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааны хэрэгжилтийг цаг хугацаандаа тайлагнахыг үзлэг зохион байгуулах гэрээт эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт, үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар хангаж тайлагнахыг Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Сарнай), шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулан төсвийн зарцуулалт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс (Я.Эрдэнэтуяа)-д тус тус үүрэг болгосугай

ДАРГА  Ч.ОЮУНАА